

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ..дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь хэсэгт “эмнэлгийн мэргэжилтэн” гэсний дараа “, нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт “тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн” болон “эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн” гэсний дараа“, нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.9 дэх хэсэгт “нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого,” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тухай хууль тогтоомж” гэж, 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх хэсэгт “нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, арга хэмжээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ,” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ,” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ..дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “эх оронч сэтгэлгээ,” гэсний дараа “эрүүл амьдрах зан үйл,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ..дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий 6.29 дэх хэсгийг нэмсүгэй:

**1.1/ 6.29 дүгээр зүйл.**Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль зөрчих

1. Иргэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хуулийн этгээд нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед олон нийтийг төөрөгдүүлсэн, худал мэдээлэл тараасан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ..дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн “6.28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг,” гэсний дараа “6.29 дүгээр зүйл,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ..дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт “Эрүүл мэндийн даатгалын тухай” гэсний дараа “хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалтын “нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг